



# СОЁМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

# МЭДЭЭ

144 /144/

2021.09.28

## ЦАХИМ ШУУДАНД

### БИЕ БҮРЭЛДЭХҮҮНИЙ УР ЧАДВАРЫГ НЭМЭГДҮҮЛЛЭЭ



#### Зэвсэгт хүчний 337 дугаар анги

2020-2021 оны сургуулийн жилийн цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу байлдааны сөнөөгч онгоцны засварын төв, нисдэг тэрэг засварын төв, хангалт үйлчилгээний батальоны бүрэлдэхүүнтэй “Нисэхийн

засварын төв, ХҮБ өөрийн хүч хэрэгсэлтэйгээр заагдсан районд шилжин байрлаж, үүрэг гүйцэтгэх үеийн ажиллагаа” сэдвээр хоногийн сургуулийг зохион байгууллаа.

Хоногийн сургуулиар боловсруулсан бодлого, шийдвэрийг тактикийн түвшинд ХҮБ, нисэхийн техникийн засварын

төв хэрэгжүүлж, хээрийн байрлалд тодорхой тооны хүч хэрэгсэлтэйгээр шилжин байрлаж үүрэг гүйцэтгэх бэлтгэлжилтийг хангалаа.

Энэ хүрээнд хээрийн аэродромд нислэг хүлээн авах, аэродромын хангалт зохион байгуулах ажиллагааг станцын

тоот болон салаа, ротын түвшинд бэлтгэл жигдрэлтээ хангаж, станцуудын ажиллагааг жигдрүүлсэн байна. Хоногийн сургуулиар суралцагч нарын бие бүрэлдэхүүнээ удирдах, байлдааны баримт бичиг боловсруулах дадлага, ур чадвар дээшиллээ.



## ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ДУУЧИН “ME VOICE”-Д ОРОЛЦОЖ БАЙНА

#### Зэвсэгт хүчний 337 дугаар анги

“UBS” телевизээс нийгмийн анхдагч хэсэг болон иргэн, гэр бүл, байгууллагын оролцоог соёл урлагийн салбарт нэмэгдүүлэх зорилгын хүрээнд авьяас чадварыг илрүүлж, хөгжүүлэх замаар, хувь хүний хөгжил, нийтийн соёлыг дэмжсэн, соёл урлагийн олон талт ач холбогдол бүхий “ME VOICE” 4 дэх удаагийн үндэсний шоуг зохион байгуулж байна.

Тус шоуны нэгдүгээр шатанд

Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн бичээч, оператор У.Хонгорзул нь 1000 гаруй оролцогчоос шилдэг 54-т шалгарч 2 дугаар шатанд оролцох эрхээ авлаа.

У.Хонгорзул нь урлаг, соёлын арга хэмжээнүүдэд анги, хамт олноо төлөөлж идэвхтэй оролцдог залуу, шилдэг ажилтны нэг бөгөөд Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн хамт олны зүгээс уралдааны шалгаруулалт болон бэлтгэлийн үед шаардлагатай бүх талын дэмжлэгийг үзүүлэн ажиллаж байна.

## МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН 291.218 +1991	ЭДГЭРСЭН 304.344 +6648	НАС БАРСАН 1152 +19
-----------------------------------	---------------------------	------------------------

## ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 5215 +88	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 192	ЭДГЭРСЭН 4923
-----------------------------	----------------------------	------------------

## КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 233,068,778
Эдгэрсэн Нийт: 209,761,242
Нас барсан Нийт: 4,769,271

## Түүхэнд энэ өдөр

### 1978 он:

БНМАУ-ын Батлан хамгаалах яамны сайдаар хурандаа генерал Ж.Авхиа томилогдов. 1945 он. Улсын бага хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор Сүхбаатарын одонг бий болгожээ.

1990 он: БНМАУ-ын БХЯ-ны сайдаар дэслэгч генерал Ш.Жадамбаа томилогдов.

2007 он: Монгол-Турк улсын Тусгай хүчний хамтарсан Анадолу хамтарсан сургалт зохион байгуулах шийдвэрийг Монгол Улсын Засгийн газар батлав.

## ЦАГ АГААР

### УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
3	-6

### ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
29	16

## ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,848.00	2,851.00
EUR	3,346.0	3,354.0
CNY	441.2	442.5
RUB	38.70	39.90
JPY	25.44	25.88
KRW	2.37	2.45

## ЗУРХАЙ

2021.09.28 МЯГМАР ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 22/

НАМРЫН ДУНД УЛААГЧИН ТАХИА САР ДОЛООН УЛААН МЭНГЭТЭЙ ШАРАГЧИН ТУУЛАЙ ӨДӨР

Үс засуулбал:

Идээ ундаа элбэг олдono

Наран ургах, шингих:

06.47-18.39

Барилдлага:

Хүчин төгсөх

Шүтэн барилдлага:

Тийн мэдэхүй

Суудал:

Хий

Тухайн өдөр хонь, гахай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн бөө бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян номын үйлийг эхлэх, дээдсээс халамж хүсэх, лам хувраг болох, багш шавьд барилдах, номын авшиг авах, шинэ гэр ба байр авах, гарагийг тахиx, мал аж ахуйн үйл, удирдлагын суудалд суух, хийморийн дарцаг хатгахад сайн. Газар хагалах, ус, булгийн эх малтах, улаа гаргах, хиншүү хярвас гаргах, уул овоо тахиxад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Хол газар яваар одогсод урагш мөрөө гаргавал зохистой. Хүүхдийн сээлэг үргээлгэх буюу үс засуулбал эд, эдлэл, идээ, ундаа олдono хэмээжээ.

цахим шууданд

## ДОРНЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЧУУЛГА УУЛЗАЛТ 2021



2021 оны 9 дүгээр сарын 2-4-ний өдрүүдэд ОХУ-ын Владивосток хотноо Дорнын эдийн засгийн VI чуулга уулзалт боллоо. Өнгөрсөн хугацаанд уг чуулга уулзалт нь ОХУ болон Ази, Номхон далайн бүс нутгийн улс орнуудын урт хугацааны, үр ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх чухал тавцан болж ирсэн юм.

Энэ жил Дорнын эдийн засгийн чуулга уулзалтын хөтөлбөрт дэлхий нийтийг хамарсан КОВИД-19-ийн халдварын цар талхын үр дагаврыг даван туулах, шийдэх гарцын талаар "Шинэ цагийн эдийн засаг юу өөрчлөгдөж, юу үлдэх вэ", "Алс Дорнод-шинэ сорилт, боломжууд", "Өөрчлөгдсөн дэлхий ертөнцөд үүрэг хариуцлагаа хамтдаа үүрэх" гэсэн 4 үндсэн сэдэв багтжээ.

Мөн Залуучуудын Дорнын эдийн засгийн чуулга уулзалт зохион байгуулагдлаа. Олон улсын арга хэмжээнүүдээс дурдвал "Орос-АСЕАН", "Орос-Солонгос", "Орос-Хятад", "Орос-Энэтхэг", "Орос-Европ" гэсэн яриа, хэлэлцүүлгүүд явагдсан юм.

Дорнын эдийн засгийн чуулга уулзалтын гол арга хэмжээ нь 9 дүгээр сарын 3-нд болсон нэгдсэн хуралдаан байсан бөгөөд ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин биечлэн, Бүгд Найрамдах Казахстан Улсын Ерөнхийлөгч Касым-Жомарт Токаев, Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх нар цахим хэлбэрээр оролцлоо.

Энэхүү чуулганд Оросын Төрийн тэргүүний урилгаар дэлхийн 60 гаруй орны зочин төлөөлөгч, бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагч цахимаар болон биечлэн оролцлоо. Тус чуулга уулзалтад Казахстаны Ерөнхийлөгч Касым-Жомарт Токаев, Аргентин улсын Ерөнхийлөгч Альберто Фернандес, БНХАУ-ын дарга Ши Жиньпин, Энэтхэг улсын Ерөнхий сайд Нарендра Моди, Тайландын Вант Улсын Ерөнхий сайд Праут Чан-Оча нар цахимаар мэндчилгээ хүргэж оролцсон байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх Дорнын эдийн засгийн чуулга уулзалтын нэгдсэн хуралдаанд цахимаар оролцож, үг хэлэхдээ "Монгол Улс Евразийн эдийн засгийн холбоотой (ЕАЭЗ) чөлөөт худалдааны гэрээ байгуулах боломжийг судалж байна" гэж мэдэгдлээ.

Чуулганаар ОХУ-ын болон гадаад улсуудын томоохон компанийн төлөөлөгчдийн хооронд бизнесийн уулзалт зохион байгуулснаас гадна Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны форумын бага хурал, Их Евразийн түншлэл байгуулах тухай хэлэлцүүлгийг өрнүүлсэн байна.

Владивосток хотноо 2-4-ний өдрүүдэд болсон Дорнын эдийн засгийн VI чуулга уулзалтад оролцогчид 380 гаруй гэрээ хэлэлцээрт гарын үсэг зурлаа гэж Алс Дорнодын холбооны тойрог дахь ОХУ-ын Ерөнхийлөгчийн бүрэн эрхт төлөөлөгчийн газрын

хэвлэлийн алба мэдээлжээ. "Чуулга уулзалтын үеэр 380 гаруй гэрээ хэлэлцээр байгууллаа. Олон улсын болон гадаадын компаниуд, байгууллагууд, яамд, газруудтай 24 баримт бичигт гарын үсэг зурснаас Хятад Улстай ес, Японтой зургаа, Казахстантай гурав, Австри, Вьетнам, Канад, Серби, Өмнөд Солонгос, Этиоп улсуудтай тус бүр нэг гэрээ байгуулсан" талаар мэдээлэлд дурдсан байна.

Алс Дорнодын холбооны тойрог дахь ОХУ-ын Ерөнхийлөгчийн бүрэн эрхт төлөөлөгч Юрий Трутневийн урьд нь мэдээлсэнээр, чуулга уулзалтын үеэр нийт 3.6 их наяд рублийн үнийн дүн бүхий гэрээ хэлэлцээр байгуулжээ. ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин таван гэрээнд гарын үсэг зурахад байлцсан байна.

Дорнын эдийн засгийн чуулга уулзалтын үеэр олон улсын болон бүс нутгийн тулгамдсан сэдвээр салбар хуралдаанууд, бизнесийн уулзалт ярилцлага, дугуй ширээний ярилцлага хэлбэрээр 100 гаруй арга хэмжээ болжээ.

Энэ жилийн чуулга уулзалтыг холимог хэлбэрээр зохион байгуулсан бөгөөд 5700 гаруй хүн биечлэн оролцсон байна.

Мөн энэ удаагийн чуулганы хүрээнд энэ онд тохиож буй Монгол Улс, ОХУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 100 жилийн ойтой холбогдуулж "Орос-Монголын харилцааны түүхэн ба орчин үеийн чиг хандлага-100 жилийн ой" эрдэм шинжилгээний бага хурал болж хоёр орны түүхэн харилцааг өгүүлсэн үзэсгэлэнг дэлгэсэн байна.

Энэхүү эрдэм шинжилгээний бага хурлыг Оросын ШУА-ийн Дорно дахины судлалын хүрээлэн, Оросын түүхийн нийгэмлэг, Оросын ШУА-ийн Алс дорнодын салбарын санаачилга, Росконгрессийн дэмжлэгтэйгээр Дорно дахины эдийн засгийн чуулганы талбайд зохион байгуулжээ. Монголын талаас Монгол Улсын ШУА-ийн тэргүүн дэд

ерөнхийлөгч Г.Чулуунбаатар тэргүүтэй эрдэмтэн судлаачид, Монгол Улсын Үндэсний төв архивын захирал Т.Сайнжаргал, БХЭШХ-ийн төвийн дарга, доктор, профессор, хурандаа Б.Мөнхсайхан нарын 9 хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөгчид оролцсон байна. Олон улсын эрдэм шинжилгээний хурал чуулганы хуралдаан, 3 салбар хуралдаанаар "Орос-Монголын харилцаа түүхийн асуудлууд", "Орос-Монголын харилцааны соёл, хүмүүнлэгийн асуудлууд", "Орос-Монголын харилцаа, улс төр, цэрэг, худалдаа, эдийн засгийн асуудлууд"-ыг хэлэлцсэн байна.

Доктор Б.Мөнхсайхан өөрийн илтгэлдээ хоёр улсын батлан хамгаалахын хамтын ажиллагааны сүүлийн 30 жилд өрнөсөн үйл явдлыг нэгтгэн дүгнээд, цэрэг болон цэрэг-техникийн уламжлалт харилцаа улам сайжирч хоёр орны ард түмний сонирхол, ардчиллын нийтлэг зарчмын үндсэн дээр талуудын харилцааг эрх зүйн хувьд бэхжүүлэх, шинэтгэх шинэ зорилт үүсэж байгааг цохин тэмдэглэсэн байна.

Ялангуяа хоёр улсын батлан хамгаалахын сайд нарын харилцан айлчлал, уулзалт, хэлэлцээр, санал солилцох зэрэг олон үйл ажиллагааны үр дүнд энэ салбар дахь цаашдын хамтын ажиллагааг улам тэлэх сонирхлыг өргөжүүлж байна.

Энд мөн хоёр улсын цэргийн хамтын ажиллагааны хүрээнд зохиогдож буй хамтарсан хээрийн сургууль, дадлага, цэрэг-техникийн хамтын ажиллагааны хүрээнд нийлүүлсэн зэвсэглэл, техникийн шинэчлэл; цэргийн албан хаагчдын сургалт, давтан сургалт; олон улсын цэргийн тоглолтын хүрээнд оролцсон болон зохион байгуулсан уралдаан тэмцээнүүд; Их ялалтын болон Халхын голын дайны ялалтын түүхт ойн жилүүдэд хоёр ард түмний найрамдал улам ойртон бэхжиж байсан талаар, цаашилбал дэлхий нийтийг хамарсан CO-VID цар тахлын үед ч биедээ харилцан тусалцаж байсан талаар дэлгэрэнгүй илтгэсэн байна.

Хурандаа Б.МӨНХСАЙХАН



## УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН БОЛОВ



Зэвсэгт хүчний 065 дугаар анги

2021 оны 9 дүгээр сарын 25, 26-ны өдрүүдэд Харилцаа холбоо, Мэдээллийн Технологийн салбарын 100 жилийн ойг тохиолдуулан

зохиож буй Харилцаа Холбооны Зохицуулах Хорооны нэрэмжит 2021 оны "Радио сонирхогчийн нэвтрүүлэгч олох улсын аварга шалгаруулах тэмцээн"-д болов. Тэмцээнд Зэвсэгт

хүчний 065 дугаар ангийн дэд ахлагч П.Тэмүүжин ахлагчтай баг тамирчид дэд байрт шалгарлаа. Тэмцээнийг М19/М35, М/21, W19/W35, W21 ангиллаар уламжлалт 144 МГц, 3,5МГц төрлөөр зохион байгуулснаас хувийн амжилтаар зангилгааны дарга, ахмад Ц.Одгэрэл, уламжлалт 144 МГц-ийн төрөлд тэргүүн байр, 3,5МГц-ийн төрөлд дэд байр, нийлбэр дүнгээр хоёрдугаар байр, хорооны командын байрын радиотелеграфчин, сургагч ахлагч Ш.Одончимэг, 144 МГц-ийн төрөлд трэргүүн байр, 3,5МГц-ийн төрөлд тэргүүн байр, нийлбэр дүнгээр нэгдүгээр байр, хорооны командын байрын радиотелеграфчин ахлагч Ч.Чулуунчимэг 144 МГц-ийн төрөлд дэд байр, нийлбэр дүнгээр гуравдугаар байрт шалгарлаа.

## АГААРЫН ЦЭРГИЙН ЭМЧ НАР АВХААЛЖТАЙ БАЙЛАА



Зэвсэгт хүчний 065 дугаар анги

Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын эмч, эмнэлгийн мэргэжилтний дунд зохион байгуулсан "Цэргийн эмнэлгийн тусгай бэлтгэл-2021" буухиа тэмцээн энэ сарын 23-24-ний хооронд Зэвсэгт хүчний Хужирбулан сургалтын нэгдсэн төвд амжилттай зохион байгуулагдлаа.

Тус тэмцээнд Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын эрэгтэй,

эмэгтэй 2 баг тамирчид оролцсоноос эрэгтэй баг тамирчдаас буудлагын төрөлд Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн инженер дунд зохион байгуулсан "Цэргийн эмнэлгийн тусгай бэлтгэл-2021" буухиа тэмцээн энэ сарын 23-24-ний хооронд Зэвсэгт хүчний Хужирбулан сургалтын нэгдсэн төвд амжилттай зохион байгуулагдлаа.

Эмэгтэй багийн Саадын зурвасын төрөлд Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн хорооны командын байрын радиотелеграфчин, ахлагч М.Ариунтуяа бусдыгаа хошуучлан тэргүүн байрт шалгарлаа. Тус тэмцээний эрэгтэй, эмэгтэй баг тамирчдыг Агаарын цэргийн командлалын харьяа 065, 337, 353 дугаар ангиудаас сонгон шалгаруулж оролцсон билээ.

Ахмад З.АНХБАЯР

## ҮНДЭСНИЙ БАТЛАН ХАМГААЛАХЫН ИХ СУРГУУЛЬ НЭМЭЛТ ЭЛСЭЛТ АВНА

Улс орны батлан хамгаалах эрэлт, хэрэгцээ шаардлагын дагуу ҮБХИС нь нэмэлт элсэлт авч эхэллээ. Тодруулбал, эдийн засаг, менежмент, авто инженер, цэргийн хими хамгаалалт, зенитийн артиллери, зенитийн пуужин, радиотехникийн команд, цэргийн зэвсэглэл, артиллери, цэргийн инженер, хуягт танкийн команд гэсэн мэргэжлээр 9 дүгээр сарын 27-аас 30-ны өдрүүдэд 10.00-16.00 цагийн хооронд элсэгчдийг бүртгэж байна. Бүртгүүлэгчид нь Цэргийн мэргэжлийн бакалаврын

хөтөлбөрт элсэгчид 165 см-ээс дээш өндөртэй, 60 кг-аас багагүй жинтэй, биед шивээсгүй, биеийн ил хэсэгт сорвигүй, элдэв гаж зуршилгүй, сэтгэц эрүүл байх шаардлагуудыг хангасан байна. Эх орноо батлан хамгаалах их үйлсэд хүчин зүтгэхийг хүсэгч хэн бүхнийг ҮБХИС урьж байна.

Холбогдох утасны дугаар: 453164, 89090682, 99077929

Бүрдүүлэх бичиг, баримт: - Иргэний үнэмлэхийн хуулбар /2 хувь/;

- Элсэлтийн ерөнхий шалгалтын батламж /2019, 2020, 2021/;

- Б о л о в с р о л эзэмшсэнийг гэрчлэх баримт бичиг;

- Сурагчийн хувийн хэрэг;

- 3x4 хэмжээний цээж зураг /4 хувь/;

- Төгссөн сургуулийн тодорхойлолт;

- Өөрийн суралцах бэлтгэл, авьяас чадвар, туршлага, хувийн зан чанар, хэрхэн суралцахаа илэрхийлсэн эсээ бичлэг;

- Гурван үеийн намтар.

